



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 13-нд

Дугаар 52

Алтай хот

Тэмдэгтийн хураамжийн хэмжээ
тогтоох тухай

Монгол улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 600 000 төгрөг, бусад сумд 300 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад аймгийн төвийн сумд 200 000, сумдад 100 000 төгрөг байхаар тогтоосугай.
2. Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 200 000 төгрөг, бусад сумдад 100 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад аймгийн төвийн сумд 70 000, сумдад 40 000 төгрөг байхаар тогтоосугай.
3. Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 800 000 төгрөг, сумдад 500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад аймгийн төвийн сумд 400 000, сумдад 200 000 төгрөг байхаар тогтоосугай.
4. Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 400 000 төгрөг, бусад сумдад 250 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад аймгийн төвийн сумд 200 000, сумдад 120 000 төгрөг байхаар тогтоосугай.
5. Сүү сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг байхаар тогтоосугай.
6. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн хэмжээнд 250 000 төгрөг байхаар тогтоосугай.
7. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2011 оны 12-р сарын 01-нээс эхлэн мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Амгаланбаяр/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Ш.ЭРДЭНЭБАТ